

Манмин Мэдээ

Номер 30 2013оны Нэгдүгээр сарын 20

Пакистан, Шри Ланка улсыг шинэчлэж буй Ариун Сүнсний хүчит салхи

Гил Тэ шиг пасторыг урьсан номлогчдын семинар болон гар алчуурын цуглаан



Амин үгс болон Бурханы эрх мэдэлт хүч чадлын нөлөө Пакистан болон Шри Ланка-д хүчээ авлаа. ■ Зураг 1: 10,000 гаруй хүмүүс цугласан Пакистан дах гар алчуурын цуглаан ■ Зураг 2: Шри Ланка Кирулнапаонад болсон гар алчуурын цуглаан ■ Зураг 3: Эрх мэдэлт хүчит гар алчуураар залбирал хийж буй Гил Тэ шиг пастор ■ Зураг 4-5: Өвчнөөсөө эдгэрч, Бурханд алдрыг өргөж буй гэрчлэлүүд ■ Зураг 6: Пакистанд хийж гүйцэтгэсэн үйлсийнхээ төлөө Гил Тэ шиг пастор эрдмийн зэрэг цолоор шагнуулж байгаа байдал (дунд талынх)

Хүн амын 97% нь Лалын шашинтай Пакистан улс ба мөн хүн амын 69% Буддийн шашин зонхилох Шри Ланка улсад ч сайн мэдээ болон дагалдах тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчит үйлсийн нөлөө гал мэт газар авч байна. 2012 оны Аравдугаар сарын 16-наас 26-ны хооронд, Гил Тэ шиг пастор нь (Дейжон Манмин Сүмийг хариуцагч) Манмины номлолын багынхантай хамт Пакистан, Шри Ланка улсууд руу сайн мэдээний ажлаар яваад ирсэн юм.

Аравдугаар сарын 17-нд, Пакистан улс, Лахоре хотын Амбассадор зочид буудалд Гил Тэ шиг пастор докторын диплом гардуулах ёслол болж өнгөрөв. Пакистаны Үндэсний сүмийн нэгдсэн холбооноос зохион явуулсан уг арга хэмжээнд Гил Тэ шиг пасторын Пакистанд хийсэн олон удаагийн сайн мэдээ тараах үйл ажиллагааг болон Пакистан улсад хийж бүтээсэн гавьяаг үнэлэн эрдмийн зэрэг цолоор шагнав. Гил пастор нь сүүлийн арван жилийн турш нийт 14 удаа Пакистан улс руу айлчлан

очиж номлогчдын семинар, гар алчуурын цуглаануудыг нийт 12 хотуудад зохион байгуулсан билээ. Мөн түүнчлэн, NGO Төрийн бус байгууллагаас Доктор И Жейруг пасторд энэ мэт олон хүмүүсийн төлөөх үйлчлэлд талархлаа илэрхийлэн “Сайн Самаританы шагнал”-ыг дамжуулсан юм.

Үүний дараа семинарын үйл ажиллагаа явагдан, Гил Тэ шиг пастор Доктор И Жейруг пасторын “Сэргэтэн Израйль” хэмээх номонд дурдагдсан хүн төрөлхтөний дасгалжуулалт ба үүний зорилгын талаар уг семинарт оролцогчдод дамжууллаа. Тэр орой нь Исаак ТВ-ын захирал Анвар Фазал пасторын хүсэлтээр Гар алчуурын цуглаан болж явагдав. Гил Тэ шиг пастор “Есүс бидний Аврагч болсон 4 нөхцөл”-ийн тухай сургаал айлдан, өвчтэй хүмүүсийн төлөөх гар алчуураар (Үйлс 19:11-12) залбирал хийж өгсөн юм.

Аравдугаар сарын 18-нд, Анвар Фазал пасторын удирдлагаар “Амин Ус” сүм дээр номлогчдын семинарыг зохион байгуулахад Гил Тэ шиг пастор “Итгэлийн

хэмжээ” хэмээх сэдэвт сургаал айлдсан юм. Семинарт оролцогчид тус сургаалыг ихэд баярлан хүлээн авцаасан ба цаашид үргэлжлүүлэн энэ мэт Доктор И Жейруг пасторын сүнслэг сургаалиудыг хуваалцахыг хүсэж байлаа.

Аравдугаар сарын 20-нд, Шри Ланка улсын Колумбо хотын Кирулнапона дүүрэгт болсон гар алчуурын цуглаанд “Хүн төрөлхтөнийг дасгалжуулж буйн учир” болон “Сайн мууг мэдүүлэгч жимсний модыг тавьсан тухай” сургаал айлдаж, 21-нд, тэрбээр Вадала мужид гар алчуурын цуглааны үеэр “Есүс Христ”-ийн тухай сургаал тус тус айлдсан билээ.

Энэ 2 өдрийн гар алчуурын цуглаанаар дамжуулан төрөл бүрийн өвчин хөндүүр байдлууд арилж, олон хүмүүс амьд оршигч Бурханд алдрыг өргөж байлаа. Амьсгалын замын үрэвсэл, астма өвчний улмаас 5 жил амьсгалын аппаратаар амьдарч байсан Гияан Даясинхе (эрэгтэй 6 настай) гэх хүүд цээж болон хоолойд халуун дулаахан мэдрэмж төрснөөр бүрэн

эдгэрч, С. Нихал Фернандо (эрэгтэй 51 настай) авто ослын дараах өвчин зовиуртай байдал нь бүгд алга болсон хэмээн гэрчилж, Бриджет (эмэгтэй 60 настай) нүдний хараа сайжирч, Маратиа гэх (65 эмэгтэй) нуруу, нугасны өвчнөөсөө бүрэн эдгэрсэн зэрэг эдгэрлийн гэрчлэл арвин дүүрэн байлаа.

Аравдугаар сарын 22-нд, Гил Тэ шиг пастор Коломбод номлогчдын семинарыг зохион явуулж, “Итгэлийн хэмжээ” хэмээх сургаалийг айлдав. Цуглаанд оролцсон пасторууд, “Сургаал нь Библийн үндсэн гол сэдэвтэй ба сүнслэг гүн ухагдахуунтай байлаа” хэмээн сэтгэл өндөртэйгөөр өөрсдийн сэтгэлээ хуваалцаагаж байлаа. Аравдугаар сарын 23-нд, “Загалмайн үг” хэмээх сэдэвт номлогчдын семинар Кэнди-д болж өнгөрөв. Энэ удаагийн семинар болж өндөрлөснөөр бүх ажиллагаа төлөвлөгөө ёсоор болж номлолын багынхан буцах болж. Ариун сайн мэдээ жинхэнэ амтыг мэдрсэн тэдгээр сүмийн удирдагч нар дараа дараагийн семинарыг тэсэн ядан хүлээж байна.

Исаак ТВ-р дамжуулан Доктор И Жейруг пасторын сургаалуудыг илүү олон хүмүүст түгээгдэж...

Пакистаны Исаак ТВ-р дамжуулан илүү олон хүмүүс амьсгалын Бурханы сургаалыг сонсох боломжтой боллоо.

Исаак ТВ нь Доктор И Жейруг пасторын сургаалуудыг Англи ба Урду хэлээр өдөрт зургаан цагын турш нэвтрүүлдэг ба Пакистан болон Ойрхи Дорнодын улсуудад тараан цацагдаж, өдөр бүр 2 цагын турш Манмины магтаал дууны тоглолтуудыг нэвтрүүлдэг билээ.

Исаак ТВ-ын захирал Анвар Фазал пастор “Сүүлийн үед Исаак ТВ нь Англи, Европ болон Африкийн орнуудад нэвтрүүлгээ цацан гаргах гэрээ хийн, нэвтрүүлгээ цацаж эхлээд байна. Үүгээр дамжуулан маш олон хүмүүс үнэнийг мэдэн, авралд хүрэх болно” хэмээн дурдлаа.



Махан Биеийн Хайр болон Сүнслэг Хайр

Хайртууд минь, бие биеэ хайрлацгаая. Учир нь хайр бол Бурханаас ирдэг. Хайрладаг хүн бүр Бурханаас төрсөн бөгөөд Бурханыг мэддэг юм. Хайрладаггүй нэгэн нь Бурханыг мэддэггүй. Учир нь Бурхан бол хайр билээ. (1 Иохан 4:7-8)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Хайр гэдэг үгийг сонсоход л бидэнд аз жаргал болон сэтгэл хөдлөл ба ариун сайхан мэдрэмж төрүүлдэг билээ. Хэн нэгнийг хайрлаж амьдрахдаа, хувиршгүй хайрыг өгч авалцдаг бол түүнээс илүү аз жаргал гэж үгүй биз ээ. Зарим үед хайрын хүчээр үхлийг ялан дийлж, нөхцөл байдлыг өөрчлөн амьдралаа үзэсгэлэнтэй, нандин болгосон хүмүүсийн бид олонтой олж сонсдог. Хайр нь аз жаргалын салшгүй нэгэн хэсэг бөгөөд хайр дотор бидний амьдралыг өөрчлөх агуу увидаас оршдог.

1. Махан Биеийн хайр гэж юу вэ?

Өөрт нь сайн ханддаг болон ямар нэг талаараа өөрт нь ашиг тус болох хүнийг хайрладаг хүн нь Бурханыг мэддэггүй хүн бөгөөд атгаг хорон муу хүн ч үүн шиг үйлдэж чаддаг билээ. Гэвч тэдний хайр нь гаднаа чин үнэнч хайр мэт боловч дотроо бодит зүйл биш тул энэ нь жинхэнэ хайр биш байдаг. Энэ нь цаг өнгөрөх тусам хувирч, өчүүхэн зүйлд ч амархан бутрах махан биеийн хайр учраас тэр юм.

Махан биеийн хайр нь цаг хугацаа өнгөрч, мөн нөхцөл байдал өөрчлөгдвөл амархан хувирдаг. Өөрийн ашиг сонирхолоос шалтгаалан энэ хайр нь өөрчлөгдөж байдаг. Бусдаас ямар нэгэн зүйл авч байж, өгөх ч юм уу, өөрт нь ашигтай үед л хариу үйлдэл хийдэг ба энэ мэт өөрөө өгсөний хэмжээгээр бусдаас авахыг хүсдэг ба нөгөө хүн нь өгөхгүй бол гомдоллож, харамсдаг байдал нь бүгд махан биеийн хайр юм.

Эцэг эхчүүд үр хүүхдээ чин сэтгэлээсээ хайрлаж, өсгөн хүмүүжүүлдэг ч тэдний зарим нь хүүхдүүдээ өөрсдөө нэр хүнд болон ашиг сонирхлын төлөө хүмүүжүүлдэг эцэг эхчүүд ямар их байдаг билээ. Тэд, үр хүүхдүүдээ хэлэхдээ “Энэ бүгд чиний л сайн сайхны төлөө юм” гэж хэлдэг ч өөрийн сэтгэл хангалуун байдлын төлөө юм уу үр хүүхдээрээ бахархан, сайрхах сэтгэл байгаа учраас юм. Үр хүүхдүүд нь өөрсдийн замыг сонгох үед мөн амьдралын

ханиа сонгоход эцэг эхийнхээ хүслээс зөрөх үед тэд хүүхдүүдээ гомдоллож, мөн тэднийг эсэргүүцэн дургүйцлээ илэрхийлдэг. Энэ нь эцэстээ үр хүүхдийнхээ төлөө гэсэн үйлдэл ба золиос бус өөрсдийгөө л гэсэн нөхцөл байдал шаардсан зүйл гэдгийг илэрхийлж байгаа юм.

Тэгвэл үр хүүхэд нь эцэг эхийг хайрладаг сэтгэл нь ямар байдаг вэ? Улиг өвчин уур барна гэдэг шиг хүүхдүүд эцэг эхийг хөгширч өглөн, өвчин тусвал төвөгшөөж, үл тоомсорлох тохиолдол байдаг. Ажилтай завгүй байна гэсэн шалтгаар хол газар амьдарч байгаа эцэг эхийнхээ мэндийг мэдэх юм уу утсаар ярихад ч хүртэл хэцүү байдаг. Тэд бол өөрсдийн амьдрал болон үр хүүхэд нь чухал бөгөөд бага багаар өөрсдийн эцэг эхээ үл тоомсорлодог. Ялангуяа эцэг эхээсээ эд хөрөнгө, мөнгө гуйхад өгөхгүй бол үзэн ядах юм уу тэр ч бүү хэл энэ явдал даамжирвал эцэг эхээ ч алдаг суртахуунгүй хүүхэд ч байдаг.

Тэгвэл найз нөхдийн хайр нь ямар вэ? Төмөр мэт бат итгэж байсан найз нь өөрийг нь золиослосноор сэтгэлдээ том шарх авах үе байдаг билээ. Зарим тохиолдолд яаралтай мөнгө хэрэг болсон үед найзууд болон дотны найзаасаа мөнгө гуйх юм уу эсвэл хэн нэгний зээлийн батлан даагч болохыг хүсдэг. Гэвч найз нь татгалзахад өөрөөс нь урваж байна гэх мэт сэтгэлээр унан, гомдоллож тэдний харилцаа ч хөндий болдог билээ. Хэрэв эрхэм та хэн нэгнийг чин үнэнчээр хайрладаг бол ямар ч хүнд нөхцөлд байсан ч гэсэн бусдад хор хохирол учруулахыг хүсдэггүй байх билээ. Ингэж махан биеийн хайр бол өөрийн хүсэл нөхцөл байдлыг бусдад тулгадаг ба хэрэв ашиггүй бол холдож хөндийрөх шинж чанартай юм.

2. Сүнслэг хайр гэж юу вэ?

Хэлний тайлбар толь бичиг дээр “хайр” гэдэг нь “ямар ч нөхцөлд хэн нэгэний төлөө харамгүйгээр зориулах сэтгэл” гэж тодорхойлсон байдаг. Гэтэл Бурханы айлдаж буй хайр нь толь бичигт дурдагдсан хайраас хамаагүй өндөр түвшний сүнслэг хайр гэсэн үг юм. Сүнслэг хайр гэдэг нь бусдын тусын тулд, баяр баясгалан, итгэл найдвар, тэдэнд амийг өгдөг төдийгүй мөнхөд хувиршгүй хайрыг хэлж байгаа юм.

Библи дээр Давид болон Ионатан нар ийм сүнслэг хайрын тухай гардаг. Ионатан нь Израйлийн хамгийн анхны хаан Саул хааны хүү байв. Тэрээр Давид хэдэн мөлгөр чулуугаар Филистийн аварга биет цэрэг Голиатыг унагааж байгааг хараад Бурханы Сүнстэй баатар хүн болохыг мэдсэн юм. Ионатан өөрөө ч гэсэн цэрэг удирдагч жанжин байсан болохоор түүний эр зоригыг хараад сэтгэл сэргэж, эрч хүч авсан юм. Тэр цаг үеэс хойш Ионатан Давидыг өөрийн амь шигээ

хамгаалан хайрладаг байв. Мөн Давидад ямар ч зүйл зориулахдаа харамсаж байгаагүй юм.

1 Самуел 18:1-4-д, “Давид Саултай ярилцаж дуусахад, Ионатаны сэтгэл Давидын сэтгэлтэй нийцэв. Ионатан Давидыг өөрийн адил хайрлалаа. Саул тэр өдөр Давидыг үлдээн, эцгийнх нь гэрт буцаасангүй билээ. Ионатан Давидыг өөрийн адил хайрласан тул Давидтай гэрээ байгуулав. Ионатан өмсөж байсан гадуур дээлээ тайлж, өөрийн хуяг дуулгыг илд, нум сум, бүс зэргийн хамт Давидад өгөв”.

Ионатан Саул хааны ууган хүү бөгөөд хаан ширээг залгамжлах байсан ч түүнд энэ талаар шунах сэтгэл байхгүй байлаа. Харин ч эсрэгээр Саул хаан Давидыг хаан ширээнд суулгахгүйн тулд алах гэжээ Ионатан амь биеэ үл хайрлан хамгаалж өгсөн ба энэ хайр нь үхэн үхтэлээ хувиршгүй байсан юм.

Ионатан Гилбоа хэмээх уулын ойролцоох болсон тулалдаанд амиа алддаг ба Давид үүнд ихэд харамсан гашуудан мацаг барьдаг билээ. Мөн тэрээр хаан болсоныхоо дараа Давид Ионатаны хүү болох Мефибошетийг олж өвөг эцэг болох Саулын бүх эд хөрөнгийг нь түүнд буцаан өгч хааны ордонд өөрийн хүү мэт асардаг.

Энэ мэт сүнслэг хайр нь хэдийгээр өөрт нь үр ашигтай биш харин ч хохирол учруулсан ч амиа зориулах мэт хувиршгүй сэтгэлээр хайрладаг билээ. Ямар нэг нөхцөлийг хүсэх ч юм уу өөрт нь сайн ханддаг гээд хайрладаг зүйл биш юм. Сүнслэг хайр гэдэг нь ямар ч нөхцөл тохиолдолд даруухнаар өөрийгөө зориулдаг хувиршгүй хайрлахыг хэлдэг билээ.

3. Бидэн рүү хандсан Бурханы мөн Эзний хувирашгүй агуу хайр

Магадгүй та бүхэн сүнслэг хайрын эсрэг тал болох махан биеийн хайраас сэтгэл өвдөж байсан үе бий юу? Амархан хувирч, сэтгэл өвдөн ганцаардах үед биднийг тайтгаруулж өгдөг Цорын ганц итгэх найдах хүн байдаг. Тэр нь бидний Их Эзэн билээ.

Эзэн огтхон ч гэм нүгэлгүй ч гэсэн хүмүүст гадуурхагдаж, доромжлуулж байсан бөгөөд хэнээс ч илүү бидний сэтгэлийг сайн мэддэг билээ. Тэнгэрийн алдарыг орхин энэ газар дээр ирж, зовлонг замаар явсан учир бидний жинхэнэ Тайтгаруулагч, болон загалмай дээр үхэх хүртлээ жинхэнэ хайраар биднийг хайрласан билээ.

Би Бурханыг хүлээн авахаас өмнө төрөл бүрийн өвчнөөр зовж ядуу тарчигхан амьдарч байлаа. 7 жилийн турш өвчтэйгөө тэмцэлдсэний эцэст надад үлдсэн зүйл бол өвчиндөө хүндэрсэн бие, уул овоо мэт хураагдсан өр зээл л байлаа. Итгэдэг, намайг хайрладаг хүмүүс маань надаас нэг нэгээрээ холдон одож би төгс орхигдон гадуурхагдсан, гутамшигт амьдрал байлаа. Өчүүхэн төдий

ч найдвар үлдэлгүй үхлийн босгон дээр төөрөлдөж байх үед Бурхан намайг хайж олсон юм.

Бурхантай уулзсаны дараа би өөрийн бүх өвчин зовлонгоосоо ангижран шинэ амь, амьдралаар амьдрах болсон юм. Бурханыг өгдөг хайр нь үнэггүйгээр өгсөн хайр байсан юм. Би эхлээд Түүнийг хайрлах биш Бурханаас эхлээд над руу гараа сунгаж, хайрласан билээ.

Исаиа 49:15-16-д Бурханы хайрыг нарийн тодорхой дурдсан байдаг. “Эх хүн хөхүүл хүүхдээ мартаж чадах уу? Төрүүлсэн хөвгүүнээ энэрэхгүй байж чадах уу? Хэдийгээр тэр мартаж болох ч, Би чамайг мартахгүй. Үзэгтүн, Би алгандаа чамайг сийлсэн. Чиний хөрмүүд үргэлж Миний өмнө байдаг”. хэмээн айлдсан байдаг.

Бүгд намайг орхин явж, харамсал гашуудах тэр л агшинд намайг орхилгүй гараа сунгасан Бурхан, Түүний хайрыг ухаарах үед эцэс төгсгөлгүй мэт нулимс урсаж байлаа. Зовлонтойгоор цаг хугацааг өнгөрүүлж байсан би Бурханы жинхэнэ хайрыг мэдэрч, одоо үй олон хүмүүсийн сэтгэлийг тайтгаруулж халамжилдаг Эзэний боол болж, Түүний ивээлийг хариулахын тулд итгэмжтэйгээр зүтгэж байгаа.

Бурхан бол хайрын уг үндэс юм. Гэмтэн бидний төлөө цор ганц Хүү Есүсийг энэ газарт илгээж өгсөн юм. Тэгээд төрөл бүрийн үзэсгэлэнтэй үнэт зүйлсээр тэнгэрийн орны байруудыг бэлдэж, нэг өдрийг 1000 жил мэт биднийг хүлээж байгаа билээ. Зүрх сэтгэл жоохон ч гэсэн нэвээл Бурханы гүн гүнзгий ариун хайрыг мэдрэх боломжтой билээ.

Хайрт итгэгч та бүхэн,

Хайр нь өөрийн эрх ашгийн төлөө хувирч өөрчлөгддөг махан биеийн хайр ба бусдын эрх ашиг, тусын тулд үнэнтэй хамт баярладаг сүнслэг хайр 2 хувааж болох юм. Бурханы хайр бол махан биеийн хайр бус, сүнслэг хайр болохыг ухааран, мөнхөд Бурхантай хувиршгүй хайрыг хуваалцахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org



Ариун байдлыг олж, хүчирхэг амьдралыг өгдөг галан баталгаа

Миний хувьд гэвэл, гэмшлийн чинь төлөө би та нарт усаар баптисм хүртээдэг. Харин миний араас Ирэгч надаас илүү хүчтэй бөгөөд Түүний шаахайг тайлах нь ч надад зохисгүй. Тэр та нарт Ариун Сүнсээр хийгээд галаар баптисм хүртээнэ. (Матай 3:11)

Есүс Христийг хүлээн авсны дараа Ариун Сүнсний болон галан баталгааг авч байж л зүрх сэтгэлдээ ариун байдлыг олон, жинхэнэ итгэлийн амьдралаар амьдрах болдог.

Ариун Сүнснийг бэлгээр хүлээн авч Бурханы үр хүүхдийн эрхийг авсан бол Ариун Сүнсний галыг авч байж л хүч өгөгдснөөр Бурханы үр хүүхэд болох ерөөлийг эдлэх болдог. Энэ мэт Бурханы хүүхдүүдэд зайлшгүй хэрэгтэй зүйл болох галын баталгааны тухай үзмэгцээ зүрх сэтгэлдээ ариун байдлыг олж, олон хүмүүсийг аврах хүчийг олохыг хүсэж байна.

Галан баталгаанд Бурханы хүч чадал оршдог

Исаиа 6-р бүлэг дээр, Исаиа эш үзүүлэгч, үзэгдэл дотор ариунхан Эзэн Бурханыг хараад “Тэгээд би-Би сүйрсэн тул надад зовлон ирэг! Яагаад гэвэл би бузар уруултай хүн. Би бузар уруултай хүмүүсийн дунд амьдардаг. Учир нь миний нүд түмэн цэргийн ЭЗЭН болох Хааныг харлаа. Тэгэхэд серафуудын нэг нь тахилын ширээнээс чимхүүрээр авсан, шатаж байгаа нүүрс гартаа барин над уруу нисэж ирэв. Тэгээд тэр миний аманд хүргэж-Харагтун. Энэ чиний аманд хүрснээр чиний бузар булай авч хаягдаж, чиний нүгэл уучлагдлаа гэв”. Энэ нь Исаиа эш үзүүлэгч галан баталгааг авч Бурханы өмнө ариун байдлтай боллоо гэсэн үг юм.

Ром 10:10-д “Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ” гэж айлдсанчлан сэтгэл зүрхэнд байгаа зүйл нь амаар гарах ба ам нь ариун байдлыг олвол зүрх сэтгэл ч ариун болдог учраас юм.

Хүний зүрх сэтгэл дотор байгаа гэмт чанарыг тэр чигээр нь авч хаяна гэдэг нь өөрийн хүчээр боломжгүй зүйл юм. Галан баталгааг үргэлжлүүлэн хүлээн авснаар гэм нүглийн уг үндсийг хүртэл шатааж ариун байдлыг олон үргэлж гэрэл дотор үйлдэх боломжтой билээ. Энэ үед гэр бүл, ажил алба, аж ахуй ч хүртэл Ариун Сүнсний галан баганаар хамгаалагдаж, сорилт шалгалт холдон зайлж, Бурханы ерөөл ба амжилттай замаар удирдуулдаг.

Дайсан сатан муу ёрын сүнснүүд ч энэ галд өртвөл тэдний хүч нь үгүй болдог ба тэд яг үхсэн мэт болдог учраас Ариун Сүнс галан багана байвал дайсан сатан диавол нь ойртож чадахгүй бөгөөд холдон зайлахаас өөр аргагүй болдог. Энэ мэт бид ч гэсэн галан баталгааг авбал зүрх сэтгэл дэх гэм нүглийн чанарыг хаяж, дайсан сатаныг ялан, Бурханы хүчээр энэ дэлхийг бүрэн ялах боломжтой билээ.

Галын баталгааг авч байж л ариун байдлыг олж хүчирхэг амьдралаар амьдрах боломжтой

Баптисм хүртээгч Иохан хүмүүсийг усан баталж байсан нь ус бол бохир зүйлийг угаадаг шиг гэм нүглээ гэмшсэн хүмүүсийн гэм нүглийг угааж буйг гадна талаар илэрхийлж буй хэрэг юм. Энэ нь хүмүүс өөрсдийн гэмээ гэмшин Аврагчаар ирсэн Бурханы Хүүг хүлээн авч авралд хүргэхийн тулд юм. Өнөө үед ч сайн мэдээг сонсоод сүмд ирвэл усан баталгааг авдаг ч Бурханы хүүхдийн хувьд ариунхан хүчтэй амьдрахыг хүсвэл Есүс Христийг хүлээн авсны дараа гэм нүглээсээ уучлагдаж, Ариун Сүнсний болон галан баталгааг авах хэрэгтэй билээ.

Есүс Христийг хүлээн авч, Ариун Сүнсний баталгааг авбал урьдын бүх л гэм нүгэл нь цэвэрхэн болж уучлагдаж. Гэвч Ариун Сүнс авсан Бурханы хүүхэд боллоо гээд дахин гэм нүгэл үйлдүүлдэг угийн гэмт чанар нь хаягдана гэсэн үг биш юм. Зүрх сэтгэл дотор гэм нүглийн уг үндэс байгаа болохоор Бурханы үгээр төгс амьдарч чадахгүй бөгөөд дайсан сатаны уруу татлаганд унан, өвчинд нэрвэгдэж, гэр бүл болон ажил албанд асуудал үүсэх ч боломжтой.

Харин үүний эсрэгээр Ариун Сүнсний баталгааг авсаны дараа үргэлжлүүлэн галан баталгааг авбал өвчин өвчин хөндүүр төдийгүй гэм нүглийн уг үндсийг хүртэл устган шатааж, сүнс махан талын асуудлуудыг нэг дор шийдэх боломжтой юм. Иймд бид залбирахдаа Ариун Сүнсний галаар нөлөөлж өгөөч хэмээн гуйх хэрэгтэй билээ. Түүнчлэн Ариун Сүнснийг хүлээн авсан Бурханы хүүхэд нь Бурханы хүч буун ирэх галан баталгааг авахын төлөө хүсэн тэмүүлэх хэрэгтэй. Үргэлж Ариун Сүнсээр бялхан галан баталгааг авснаар зүрх сэтгэл дэх агтаг байдлыг ариусган, дайсан сатан, муу ёрын сүнснүүд зайлах хүч нөлөө байж л эрүүл энх, амжилтын үндэс нээгдэх юм.

Галын баталгааг хүлээн авахын тулд Ариун Сүнсний бялхам байдал ба итгэлийн үйлстэй байх хэрэгтэй

Үйлс номын 2-р бүлэг дээр үзвэл дахин амилсан Есүс Христийн айлдсан үгэнд дуулгавартай даган Ариун Сүнсний болон галан баталгааг авсан тухай гардаг. Пентакостын өдөр дагалдагч нар Маркийн гэрт хуран цугларцаж, дээд өрөөнд нь залбирал хийж байх тэр үед хүчит салхи мэт ариун сүнсний галыг авч, хүчийг олон гарч зоригтойгоор сайн мэдээг тараасан билээ.

Бид бүхэн ч гэсэн галан баталгааг авахын тулд эхлээд Бурхан ба бидний хоорондох гэмээс болж хураагдсан ханыг нураах хэрэгтэй билээ. Тиймд эхлээд гэмшлийн залбирлаар дамжуулан гэмийн ханаа нурааж, Ариун Сүнсээр бялхам, Түүнээр удирдуулахын тулд залбирах хэрэгтэй. Ингэж байж л Ариун Сүнс буун ирж, бүх өвчин сул дорой хэсгийг шатааж, агтаг гэмт чанаруудыг ариусгаж, зүрх сэтгэлийн хүсэлдээ хариулт авах боломжтой байдаг.

Мөн түүнчлэн, галын баталгаа нь Бурханы хүч чадлын түвшнийг учир зайлшгүй итгэлийн үйлс байж авах хэрэгтэй. Тэр хэмжээгээр үнэн дотор үйлдэж байж л зайлшгүй Бурханыг баярлуулах залбирал ба магтаалыг өргөх хэрэгтэй билээ. Тэнгэр дэх сэнтийг нь донсолгох мэт дуудан залбирал ба магтаалын анхилуун үнэрийг өдөр бүр хурааж, үйлстэй итгэлээр давших үед тэнгэрээс хүч буюу галан баталгаа буун ирдэг.

Галын баталгааг эрхэм та хүлээн авбал Ариун Сүнсээр бялхам, сүнс сэтгэл тань сайжирч, бүх ажил үйлс тань бүтэмжтэй эрүүл энх, амжилтаар дүүрэн болох ерөөлийг хүртдэг. Тиймээс, Ариун Сүнсний баталгааг авсан Бурханы хүүхдүүд бол галан баталгааг авч ариун байдлыг олон, хүчтэй амьдралаар Бурхандаа алдрыг боломжтой болдог билээ.



Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57-тоот
Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

“Насан туршдаа марташгүй эрх мэдэлт хүч чадал, сургаал болон магтаал байлаа. Болгарын маш олон хүмүүст тараахыг хүсч байна”.

Би Болгар улсын София хотын ХЕМА 18 хэмээх Эмнэлгийн төвд гэр бүлийн эмчээр ажилладаг билээ. Миний аав минь гадаадад эмчийн мэргэжил эзэмшиж, тэндээ Эзэнийг хүлээн авсан тул манай гэр бүл аяндаа христчин гэр бүл болсон юм. Тухай үед Болгар улс социалист нийгэм задран унах хүртэл 1989 он хүртэл элдэв хяналт шалгалт, болон хавчлага дотор амьдарч байлаа. Тийм үед ч гэсэн манай гэр бүл Эзэний хамгаалалтан дор библи, болон итгэлийн амьдралтай холбоотой номуудыг тарааж, хэдэн христчин киног орчуулан дуу оруулж христчин хүмүүст өгдөг байлаа.

Өөрийгөө би Их Эзэний төлөө зориулсан Христийн амьдрал маань

Миний ээж дотрын эмч ба миний аав шимэгч хорхойн судлаач хүн байсан учраас би ахлах сургууль төгссөний дараа ирээдүйд ямар мэргэжилтэй болох талаар бодож компьютер эсвэл эмч болох талаар шийдэх шаардлагатай болов. Нэгэн өдөр залбирч байх зуур Эзэнээс “Эцэг эхийнхээ мэргэжлийг өвлөн ав” гэж хариулж өгсөн юм.

Анагаахын их сургуульд орох шалгалт өгөхөөс өмнө Бурхан надад нэгэн гайхамшигтай зүйлийг мэдрүүлсэн юм. Зүүдээр дамжуулан Бурхан надад шалгалтын асуултуудыг мэдүүлж өгсөн юм. Үүний үр дүнд би Софи хотын Анагаах ухааны дээд сургуульд элсэн орж, 1996 оны Арваннэгдүгээр сард төгссөн юм.

Христчин эмчийн хувьд миний хийж чадах зүйл юу болохыг эрж хайн, өөрийн амьдралаа зориулсаар ирсэн билээ. Болгарын Христэч Эмч нарын холбооны тэргүүнээр ажиллаж байхдаа би 7 хоногын сүүлээр үр хөндөлт, хувилах, бүтээл болон, үүсэл хөгжлийн талаар семинар зохион байгуулан лекц уншдаг байлаа. Эхнэрийнхээ хамт Библийн хичээлийн цугларалт, гэр бүлийн зөвлөгөө гэх зэрэг зүйлүүдийг хийдэг байлаа. Мөн сайн мэдээ тараах хүсэл маань тэр хугацаанд цагдаагийн газар, сургууль, гал командын байр, хөдөө орон нутагт ч гэсэн библийн тухай тараан түгээдэг байлаа.

Өнгөрсөн 10 жилийн сайн мэдээ тараах ажлын үр дүнд хамгийн сайн болсон нь “Библийн төсөл” байлаа. Бид 3 сая гаруй ширхэг Библи болон хүүхдэд зориулсан итгэлийн амьдралын тухай номыг тараан өгсөн явдал байв. Талархалтай нь одоогоор Болгар улс нь Европын Холбоонд багтах улсын хувьд улсын сургуульд христчин сургалт явуулах нь зөвшөөрөгдсөн цор ганц улс билээ.

Эзэний алдрын төлөө Христэч эмч нарын цугларалт болох ДХЭС-г олж мэдэн

Би бага байхдаа элэгний гепатит В вирусээр өвдөн хүнд байдалд орж байсан удаа бий. Тухайн үед би аав ээж болон итгэгч хүмүүсийн залбирлаар эдгэрч эдгэрлийн хүч нөлөөг мэдэрч байсан билээ. Өнөө



Эмч Кирил Дечков түүний эхнэр Ирина Свилениво хоёр

Тэмдэглэл

- Болгарын Христийн Эмч нарын холбооны дарга
- София хотын эмнэлгийн шинжилгээ оншлогооны төвийн ерөнхий эмч
- Болгар улсын үндэсний ЕВРОП телевизын Эрүүл Мэнд ТВ Сэтгүүл-ын ерөнхий танилцуулагч
- 2007 оны Оны Шилдэг ерөнхий эмч
- 2012 оны Дөрөвдүгээр сард болсон ДХЭС-ний Яриа өглөө

үед олон хүмүүс гайхамшиг гэж байдаггүй хэмээн ярьцгааж байдаг. Хүний биеийн талаар сайн мэддэг эмч хүн мөртлөө Бурханд итгэдэггүй явдал нь үнэхээр харамсалтай явдал билээ.

2011 оны Зургадугаар сарын 11-нд Австрали болсон ДХЭС (Дэлхийн Христэч Эмч нарын Сүлжээ)-ний тухай Олон улсын эмч нарын 8-р чуулга уулзалтанд оролцсон Доктор Лиубка Танчева гуйгаас сонсож мэдэж авав. ДХЭС нь шилдэг эмч нарын бүрэлдэхүүнтэй Бурханы хүч чадлаар эдгэрсэн гэрчлэлүүдийг анагаах ухааны зүгээс дүгнэн бататгах үүрэгтэй байгууллага юм. Би энэ ажлыг Бурханы алдрын төлөөх ажил гэдэгт баттай итгэж байна.

Үүний дараа 2012 оны Тавдугаар сарын 15 болон 16-нд, Кени улсад болсон Олон Улсын Эмч Нарын 9-р чуулга уулзалтанд оролцон үнэхээр гайхалтай сэтгэл хөдлөл ба ивээлийг авсан юм.

Доктор И Жейруг пасторын сүнслэг сургаалуудыг сонсдог болоод...

Чуулга уулзалтанд оролцохын хажуугаар ДХЭС-г үндэслэгч Доктор И Жей руг пасторын удирдаж буй Манмин Төв Сүмийнхэнтэй уулзсан юм. Тэд бүгдээр

Эзэнд итгэгч хүнд байх ёстой цэвэрхэн цэгцтэй байдал, үнэн шударга байдлыг хараад Христийн хайрыг мэдэрсэн юм. Тэд надад Доктор И Жей руг пасторын ажил үйлс болон бүх дэлхийг Эзэн рүү удирдах Манмин төв сүмийн ирээдүйн алсын харааг танилцуулсан юм.

Түүний дараа зав багатай байсан ч гэсэн би Доктор И Жей руг пасторын “Эхлэлийн тайлбар”, “Итгэлийн Хэмжээ” зэрэг төрөл бүрийн сургаалыг интернэтээр дамжуулан сонссон юм. Үүгээр дамжуулан гүнзгий сүнслэг ертөнцийг мэдэрч, зүгээр аврал авах төдий бус бидний амьдрал Эзэнийг дуурайх ёстой гэдэг нь ухаарсан юм. Доктор И Жей руг пасторын сургаал нь маш энгийн, ойлгоход хялбар мөртлөө сүнслэг гүн утгатай.

Ялангуяа хүн төрөлхтөний дасгалжуулалтын хүсэл төлөвлөгөө, Эзэн энэ газар дээр ирсэн зорилго зэргийг агуулсан “Загалмайн үг” хэмээх ном нь сүнслэг итгэлийн өсөлтөнд хэрэгтэй сургаал багтсан билээ. Мөн европ, орос, ойрхи дорнодод тархсан ТВН россия нэвтрүүлгээр дамжуулан GCN TV (www.gcntv.org) нэвтрүүлгүүдийг болон Манмин төв сүмийн магтаал дууны тоглолтуудыг шимтэн үздэг.

Манмин төв сүмд очоод шинэ хүсэл тэмүүлэлтэй боллоо

2012 оны Аравдугаар сарын эхээр Манмин Төв Сүмийн 30 жилийн ойн баяраар би Солонгос улс руу явах боломж олдсон юм. Тэнд байх хугацаандаа Бурханы улсын төлөө итгэгчдийн тасралтгүй залбирал ба маш нарийн дэг журам бүхий сүмийн үйл ажиллагааг олж харав.

Доктор И Жей руг пастортой нүүр тулан уулзах үед би түүнийг даруу төлөв Эзэнд үйлчилдэг хайраар ихтэй эрхэм гэж санагдсан юм. Доктор И Жей руг пастор нь Бурхантай сүнс зүгээр маш ойрхон харилцаатай болохыг мөн итгэгч нартайгаа маш ойр дотно харьцдаг болохыг мэдэрсэн юм.

Мөнтүүнчлэн Бурханы таалан хүлээн авах магтаал бүжгийн багийн үзэсгэлэнтэй тоглолтыг үзээд ихэд сэтгэл хөдөлсөн юм. Миний эхнэр хүртэл урлагын сургуульд заадаг хүний хувьд энэ тоглолтыг үнэхээр шилдэг хэмээж байсан юм. Есүс Христ гэсэн суурин дээр маш чадварлаг удирдагч байдаг ба итгэгчид нь үйлчлэлдээ өөрсдийгөө зориулсан Манмин төв сүм ингэж сэргэхээс өөр аргагүй сүм юм гэдгийг би ойлгосон юм.

Би Болгарт Балканы хойгын орнуудад ДХЭС-ний үйл ажиллагааны төв болоосой хэмээн залбирч байгаа билээ Болгарт буй олон сүм чуулганууд Бурханы эрх мэдэлт хүчийг мэдүүлж, Ариун сайн мэдээ ба Манмин магтаалыг дэлгэрүүлэхийг хүсч байна. Эрхэм нандин Манмины үйл ажиллагааг мэдүүлж өгч, удирдаж өгсөн Бурхандаа бүх л таорхал ба алдрыг өргөө.



ДХЭС Солонгосын Удирдлагын Ажилтнуудтай хамт Доктор Кирил Дечков эхнэрийнхээ хамт, Пастор Иван Хазарбассанов болон түүний эхнэр Габриела Хазарбассанова



Бурханы хүч чадал ундарсан Мүан амтат усны хүрээлэн (Мүан, Солонгос, Чeonнам муж)